# 5. Тайлантай ажиллах

**Тайлан** нь тухайн модулийн мэдээлэл дээр дэлгэрэнгүй комплекс анализ хийх боломжийг олгох ба цаг хугацааны давтамжтай мэдээлэл хадгалах дата агуулахтай холбогдож ажиллана.

Тайлантай ажиллахад дараах ойлголтуудыг мэдэх шаардлагатай. Үүнд:

- Тайлангийн зохион байгуулалт
- Тайлангийн бүтэц

**Тайлангийн зохион байгуулалт**

Тайлангийн зохион байгуулалт дараах бүтэцтэй байна.

**Тайлбар:**

- **Тайлангийн каталогийн хиерархи**

  Тайлан заавал нэг каталогт хамаарах ба нэг каталог нь нөгөө каталогтоо хиерахи байдлаар харъяалагдаж болно.

  - **Сонгогдсон каталог**
- **Сонгогдсон каталогийн мэдээлэл**

  Каталогийн хиерархиас каталог сонгоход тухайн каталогт харъяалагдах тайлан болон каталогийг харуулна.

  - **Сонгогдсон каталогийн нэр**
  - **Хайлт, шүүлт хийх**
  - **Харъяалагдах тайлан болон каталог**

**Тайлангийн бүтэц**

Тайлангийн зохион байгуулалтын хэсгээс тайланг сонгоход дараах цонх харагдана.




**Тайлбар:**

1. **Тайлангийн толгойн мэдээлэл**

   Сонгогдсон тайлангийн нэр болон буцах товчлуур байх ба буцах товчлуур дээр дарахад өмнөх хуудасруу шилжинэ.

2. **Тайлангийн дэд мэдээлэл**

   Тухайн тайлангийн байршлын мэдээлэл болон хэвлэх, татаж авах, тохиргоо хийх,... зэрэг тайлан дээр хийгдэх үйлдлүүдийг агуулна.

   - **2.1 Тайлангийн байршил**
   - **2.2 Тайлан дээр хийх үйлдэл**

3. **Тайлангийн шүүлт**

   Тайлангийн мэдээллийг харуулахдаа тухайн тайлангаас хамаарсан нэмэлт хайлт, шүүлт хийх боломжтой. Шүүлт хийсний дараа **Тайлан бодох** товчлуур дээр дарж тайлангаа бодуулна.

Хэрэв хайлт болон шүүлтээ арилгах бол **шинэчлэх** товчлуур дээр дарна

- **3.1 Шүүлтийн төрөл**
- **3.2 Шүүлт хийх утга**
- **3.3 Тайлан бодох болон Шинэчлэх үйлдэл**